



2024 оны 3-р сарын 20
Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс
И-мэйл: communications@amcham.mn
Утас: +976 7000-3437
Веб: <https://amcham.mn/publications/1>

Хэвлэлийн мэдээ

АмЧам Монгол “Уршиггүй уул уурхайн салбар” сэдэвт панел хэлэлцүүлгийг зохион байгуулав.



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам Монгол) 2024 оны 3-р сарын 19-ний өдөр “Уршиггүй уул уурхайн салбар” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

Уулзалтад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Дэд сайд Б. Уянга, Монголын үндэсний уул уурхайн холбооны Тэргүүн Г. Батцэнгэл, Рио Тинто Монгол компанийн Бизнес хөгжил хариуцсан захирал Э. Хонгорзул, Бадрах Энержи компанийн Гүйцэтгэх захирал М. Мелеард, Терра Эксплорерз компанийн Гүйцэтгэх захирал Р. Карпуз нар панелистаар оролцож, АмЧам Монголын Бодлого хариуцсан захирал Г. Жавхлантагс хурлыг удирдан явуулав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн Дэд сайд Б. Уянга онцлохдоо “Хөрш зэргэлдээх орнуудын тусгай хэрэгцээт болон тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нийт нутаг дэвсгэрийн 15 хүртэлх хувийг эзэлж байна. Харин Монгол Улсын хувьд энэ талбайн хэмжээ 76%-д хүрдэг. Бид хөрш зэргэлдээ орнуудаасаа яг юугаараа өөр вэ гэдэг нь тодорхойгүй байсаар байна” гэв. Мөн түүнчлэн “Хайгуулын үйл ажиллагаанаас ашиглалтын үйл ажиллагаа руу шилжих магадлал Монгол улсад 100-д 1 байгаа бол, дэлхийн ихэнх улсад 1000-д 1 байдаг. Иймд хайгуулын үйл ажиллагааг дэмжиж явуулснаар Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаана нь цаашдын уул уурхайн үйл ажиллагаа явагдах хэтийн төлөвийг мэдэж авна. Иймд бидний үйл ажиллагааг бүх нийтээр ойлгож хамтран ажиллах хэрэгтэй байна” хэмээв.

Бадрах Энержи компанийн Гүйцэтгэх захирал Марк Мелеард онцлохдоо “Зөөвч-Овоо ураны төсөл нь олон жилийн дараа Монголд хийгдэх томоохон хөрөнгө оруулалт болох ба дараа дараагийн уул уурхайн компаниудад үлгэр жишээ байна гэдэгт итгэж байгаа” гэв.

Рио Тинто Монгол компанийн Бизнес хөгжлийн захирал Э. Хонгорзул “Бид Оюутолгойд хайгуулаас эхлээд гүний уурхайгаас бүтээгдэхүүнээ гаргаж эхлэх хүртэл 20 орчим жилийг зарцуулсан. Томоохон орд газрыг эрэн хайж олоод эдийн засагт үр өгөөжтэй үйлдвэрлэлийг явуулах нь маш их хүсэл зориг, хөдөлмөр, урт хугацаа, хамгийн чухал нь тууштай байдал шаардсан ажил байдаг” гэж тэмдэглэв.

АмЧам Монголын 3-р сарын хурлаар уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй ач холбогдол, эрхзүйн орчин, уул уурхайн томоохон төслүүдийн одоогийн явц, талаар хэлэлцсэн бөгөөд уулзалтаас дараах дүгнэлтүүдийг хийв. Үүнд:

- Монгол улс уул уурхайн салбартаа ГШХО-ыг бодитоор татахын тулд төр, хувийн хэвшил хамтран ажиллаж, хөрөнгө оруулалт татах нэгдсэн стратегитэй болох ёстой. Энэ нь зөвхөн засгийн газарт бус хувийн хэвшлийн компаниудад бас хамаатай, харилцан ашигтай хамтын ажиллагааг шаардсан зүйл юм.
- Хайгуулын салбарын үйл ажиллагаа олон жилээр хоцрогдож, нөөцийн мэдээлэл ихээр хуучирсан тул хайгуулын ажил болон хайгуулын зөвшөөрлүүдийн тоог нэмэгдүүлж, төслүүдийг яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, Оюу толгой уурхайн хувьд хайгуулаас эхлээд гүний уурхайгаас бүтээгдэхүүнээ гаргаж эхлэх хүртэл 20 орчим жилийг зарцуулсан. Олон улсын жишгээр хайгуулын 100 тусгай зөвшөөрлөөс дунджаар зөвхөн 1 нь ашиглалт руу шилждэг тул Монгол улс аль болох хайгуулын ажлуудыг эрчимжүүлснээр шинэ уул уурхайн төслүүдийг ашиглалтанд оруулах хэрэгтэй байна.
- Уул уурхайн салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй ач холбогдлуудыг нийт ард иргэдэд эерэгээр, зөвөөр ойлгуулах тал дээр бүхий л оролцогч талууд хамтран ажиллах нь их чухал байна. Тухайлбал, уул уурхайн салбар нь 2023 онд ДНБ-ий 25 хувь, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 57 хувь, нийт экспортын 90 хувийг бүрдүүлдэг Монгол Улсын эдийн засгийн хөдөлгүүр, эдийн засгийн өсөлтийн чухал эх үүсвэр юм. Түүнчлэн 2023 онд улсын татварын орлогын 30 хувийг бүрдүүлсэн.
- Газрын ховор элементийн эрэлт дэлхийд нэмэгдэж байгаатай холбогдуулан Монгол улс уул уурхайг цаашид төрөлжүүлэх, ашигт малтмалын олборлолт, боловруулалт хийх бодлого баримтлахдаа сонгууль, улс төрийн нөхцөлөөс үл хамаарсан санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь чухал байна.
- Төрийн байгууллагуудын нэгдсэн уялдаа холбоог шат шатанд сайжруулснаар уул уурхайн салбарт үүсдэг ойлгомжгүй асуудлууд цэгцэрч, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх боломж бүрдэнэ. Энэ боломж хангагдсанаар хөрөнгө оруулагчид тогтвортой, урт хугацаанд хөрөнгө оруулж, эдийн засагт оруулах салбарын үр өгөөж нэмэгдэнэ.

Хэлэлцүүлгийн төгсгөлд АмЧам Монголын зүгээс хувийн хэвшилд тулгуурласан, өрсөлдөхүйц, хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн тулд салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах, томоохон төслүүдийг урагшлуулах болон салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй ач холбогдлуудыг нийт ард иргэдэд эерэгээр, зөвөөр ойлгуулах тал дээр УИХ, Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Уул уурхайн үндэсний ассоциац болон бусад оролцогч талуудтай бүхий л талаар үргэлжүүлэн идэвхитэй хамтран ажиллах болно гэдгийг илэрхийлэв.

Уулзалтын төгсгөлд АмЧам Монгол шинэ гишүүд болох “UPC Renewables”, “Eco Properties”, “Zangia.mn” байгууллагуудыг хүлээн авч, гишүүнчлэлийн сертификат гардуулав.



АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.